

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-22
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	23-41
<hr/>	
<i>1.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	23-25
<i>2.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	25-26
<i>3.Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	26-32
<i>4.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	32-41

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 30 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун;

Чөлөөтэй: Н.Ганибал, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ц.Туваан, О.Цогтгэрэл.

Нэг.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхнасан, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн зөвлөх, судлаач М.Найданхүү, Бодлого судлалын төвийн тэргүүн А.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Батжаргал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2.Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр,

дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Ж.Батжаргал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2.Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын хэлтсийн дарга Э.Уламбаатар, Газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Бордоо, ургамал хамгаалал, хөдөө аж ахуйн зохистой дадлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Отгонбаяр, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дарга М.Бямбасүрэн, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Ургамал хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч П.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар:

Ж.Батжаргал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Батжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “мал, амьтны эм” гэсний дараа “/цаашид “эм” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.5, 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“эм” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх зориулалттай, эм судлал, эмнэлзүйн болон бусад сорилт туршилтаар үйлдэл нь нотлогдсон нийлэг болон амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой хэлбэр, тун, хэмжээтэй бүтээгдэхүүнийг;”

“4.1.5.“оношлуур” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;”

“4.1.8.“эмийн туслах бодис” гэж эмийн гол үйлдлийг дэмжих, сөрөг нөлөөг бууруулах, амт, үнэрийг дарах ба нэмэгдүүлэх, эмийг хэлбэржүүлэх, найрлагыг тогтворжуулах, үйлдлийн ба хадгалах хугацааг уртасгах зэрэгт шаардлагатай бодисыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “мал, амьтны эмийн зөвлөл” гэсний дараа “/цаашид “Зөвлөл” гэх/” гэж, 5.3.1 дэх заалтын “мал, амьтны эм,” гэсний дараа “биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл,” гэж тус тус нэмж, 5.4 дэх хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3

Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “Мал, амьтны эмийн бүртгэлд /цаашид “бүртгэл” гэх/” гэж, 6.18 дахь хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3.8, 6.3.9 дэх заалт нэмэх:

“6.3.8.оношлуур;

6.3.9.тэжээллэг чанартай тэжээлийн нэмэлт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 7, 8 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

6.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.13 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 9, 10 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

7.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн Гуравдугаар бүлэг болон 10 дугаар зүйлийн гарчгийн “тэжээлийн нэмэлтийн” гэснийг “тэжээлийн нэмэлт, оношлуурын” гэж өөрчилж, 10.2.3 дахь заалтын “мал, амьтны эмийн сан” гэсний дараа “/цаашид “эмийн сан” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 11, 12, 13, 14, 15 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

9.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 15.12.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас импортлох, экспортлох энгийн зөвшөөрлийг авна.”

“15.12.6.хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөн нь тогтоогдсон;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 16, 17 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

10.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “8.1 дүгээр зүйлийн 12.12,” гэснийг “8.1 дүгээр зүйлийн 12.12-т заасан тусгай зөвшөөрлийг мал амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэж өөрчилж,” 17.2, 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.”

“17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3, 17.3.4, 17.4.4, 17.8.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 18, 19, 20 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

12. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Мал эмнэлгийн эмийг” гэснийг “Эм, тэжээлийн нэмэлтийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“20.11. Мал, амьтны эрдэс бодисын дутлыг тодорхойлох тандан судалгааг энэ хуулийн 20.12-т заасан байгууллагын захиалгаар сургалт, эрдэм шинжилгээний байгууллага таван жил тутамд бүсчлэн хийнэ.

20.12. Энэ хуулийн 20.11-д заасан тандан судалгааг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс бодисын дутлыг нөхөх, хэрэглэх талаар зөвлөмж гаргана.

20.13. Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь энэ хуулийн 20.12-т заасан зөвлөмжийн дагуу шаардлагатай эрдэс бодисыг агуулсан эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 21, 22 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

13. Төслийн 22 дугаар зүйлийн 22.4.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 23, 24 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

14. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1. Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Ж.Батжаргал: 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “хэлбэр,” гэсний өмнө “гол үйлчлэгч бодис, ” гэж, 6.7.5, 6.8.5 дахь заалтын “хорон” гэсний дараа “, эсхүл хоруу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “үр дүнгийн” гэсний дараа “харьцуулсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “хүртээмжтэй” гэсний дараа “тогтвортой” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бөөнөөр ханган нийлүүлэх” гэсний өмнө “эмийн санд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын “түдгэлзүүлэх,” гэсний дараа “цуцлах” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтын “тайланг хэлэлцэж, зөвлөмж өгөх” гэснийг “тайлантай танилцах” гэж, 5.6 дахь хэсгийн “төсөвт тусган санхүүжүүлнэ” гэснийг “төсвийн төсөлд тусгана” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “тусламжаар импортлох” гэснийг “тусламж, хандивын” гэж, 6.3.2 дахь заалтын “эм” гэснийг “бүтээгдэхүүн” гэж, 6.4 дэх хэсгийн “зориулалтыг зааж” гэснийг “зориулалт, жороор олгох эсэхийг зааж” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалтын “үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “хүн эмнэлгийн зориулалт бүхий” гэснийг “хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “лиценз” гэснийг “энгийн зөвшөөрөл” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо” гэснийг “Энгийн зөвшөөрөл хүсэгч нь” гэж, 17 дугаар зүйлийн 17.8.1 дэх заалтын “бүрдүүлж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих” гэснийг “бүрдүүлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “журам, эмийн жагсаалтыг” гэснийг “журмыг” гэж, 20.5 дахь хэсгийн “бүртгэж, улирал бүр цахим мэдээллийн санд оруулна” гэснийг “бүртгэнэ” гэж, 20.7 дахь хэсгийн “сөрөг үйлдэл болон хэрэглээний горимыг” гэснийг “гаж нөлөө, хэрэглэх зааврыг” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 11.2.2 дахь заалтын “эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мал эмнэлгийн байгууллага, мал, амьтны эмийн санд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.10.2 дахь заалтын “хамтын ажиллагааны болон төслийн” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн тогтоож, өөрийн орны судалгааны дүн болон” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.3.7 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

3. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

5. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

6. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

7.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Уг асуудлыг 20 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхнасан, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарч байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулья гэсэн горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Ганибал, Б.Саранчимэг, Ц.Идэрбат, Т.Энхтүвшин /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд шинээр 4.1.7, 4.1.8 дахь заалт нэмэх:

“4.1.4.“хот айл” гэж хоёр ба түүнээс дээш малчин өрх хамтран хөдөлмөрөө хоршин мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрийг;

4.1.5.“мал аж ахуйн зохистой дадал” гэж бэлчээрийг хамгаалах, мал маллагаа, малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, ашиг шим, түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг хангах арга барил, үйл ажиллагааг;

4.1.7.“мал” гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.8.“малчин өрх” гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-м заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дахь заалтын “урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд” гэсний дараа “хамрагдах хүсэлт гаргасан малчныг жил бүр” гэж нэмж, 5.1.6 дахь заалтыг 5.1.6, 5.1.7 дахь заалт болгож, 5.2, 5.3 дахь хэсэг, 5.2.1, 5.2.3, 5.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэл даах чадавхыг бүрдүүлэх;

5.1.7.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшинг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх;

5.2.Засгийн газраас энэ хуулийн 5.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэхээс гадна дараах арга хэмжээг авна:

5.2.1.мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт, шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

5.2.3.мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хөнгөлөлттэй зээл болон бусад хэлбэрээр дэмжих;

5.2.7.гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин нь ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгох;

5.3.Энэ хуулийн 5.2.4, 5.2.5, 5.2.6, 5.2.7, 5.2.8, 5.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдох харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, ГУРАВДУГААР БҮЛЭГТ шилжүүлэх.

МАЛЧНЫ ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

6 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг

6.1.Малчин дараах эрх эдэлнэ:

6.1.1.уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн нөхцөлд мал маллах арга ухааныг эзэмшиж, мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилаа ахиулж, малчинд зориулсан сургалт мэдээлэл, зөвлөгөө авах;

6.1.2.байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах;

6.1.3.төрөөс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээ авах;

6.1.4.малын эрүүл мэндийг хамгаалах болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг эрх бүхий нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, зөвлөгөө авах;

6.1.5.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, нэр төрөл, чанараас хамаарсан урамшууллыг хууль тогтоомжийн дагуу авах;

6.1.6.хуульд заасан бусад эрх.

6.2.Малчин дараах үүрэг хүлээнэ:

6.2.1.байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

6.2.2.мал маллагааны уламжлалт болон шинжлэх ухаанч арга барилыг эзэмших;

6.2.3.малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах;

6.2.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах;

6.2.6. хуульд заасан бусад.

6.3.Энэ хуулийн 6.2.1-д заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.3.1.малчин өрх, хот айл бэлчээрээ дундаа хамтран ашиглаж ирсэн уламжлалд тулгуурлан харилцан зөвшилцөж, зохион байгуулалтад орсон байх;

6.3.2.бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх;

6.3.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хадлан, гар тэжээл бэлтгэх.

6.4.Энэ хуулийн 6.2-2-г заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.4.1.мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг өөрийн малын тоо толгойд нийцүүлэн бүрэн хангаж, 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, тэжээл бэлтгэж нөөцлөх;

6.4.2.малын хэвтэр бууц, хашаа, хороог байнга цэвэрлэж, өвөлжөөний хөрзөнг жил бүр авдаг, өтөг хөрзөнг овоолж хэвтрийн нөөц бүрдүүлдэг байх;

6.4.3.өвөлжөө, хаваржааны дулаан хашаа, хороо, байр барьж ашиглах;

6.4.4.дөрвөн улиралд нүүдэллэн бэлчээр ашиглахдаа байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдлыг ил задгай үлдээхгүй байх;

6.4.5.худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлах;

6.4.6.мал маллах, хариулах, тууварлах, тээвэрлэхдээ уламжлалт арга барилыг түлхүү ашиглах.

6.5.Энэ хуулийн 6.2.3-г заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.5.1.тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн, баталгаажсан үүлдэр, омгийн хээлтүүлэгч ашиглах, малыг ялган тэмдэглэх, бүртгэлд хамруулах;

6.5.2.малын төрлийн харьцаа, сүргийн зохистой бүтцийг хангаж, эдийн засгийн эргэлтэд оруулах;

6.5.3.тухайн үүлдэр, омгийн нэгж малаас авч болох ашиг шимийн дундаж гарцаас багагүй хэмжээний ашиг шим авах;

6.5.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 3 жил тутамд чанарын үнэлгээ хийлгэх;

6.5.5.мал эмнэлгийн болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг мэргэжлийн нэгжээр гэрээний үндсэн дээр технологит хугацаанд гүйцэтгүүлэх;

6.5.6.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, гарал үүслийг тогтоох нөхцөлийг бүрдүүлж, малын шилжилт хөдөлгөөний талаар эрх бүхий байгууллагад мэдээлдэг байх;

6.5.7.эмийн үлдэц агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

6.6.Энэ хуулийн 6.2.4-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.6.1.малын ноос, ноолуур, хөөврийг технологийн хугацаанд холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын ялгаатай байдлаар ангилан тордож, бэлтгэн нийлүүлэх;

6.6.2.малын мах бэлтгэлийг хийхдээ малын арьс ширийг механик гэмтэлгүйгээр хоёр цагийн дотор цэвэрлэгээ, анхан шатны тордолтыг хийж, холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын хамгаалалттайгаар бэлтгэх;

6.6.3.сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхдээ эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.6 дахь хэсэг, 7.5.3, 7.5.4, 7.5.7 дахь заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулж, 7.2 дахь хэсгийг хасах.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан хөтөлбөр нь сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцсэн байна.

7.5.3.малын чанарыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал маллах, арчлах болон сувилгааны арга аргачлалын талаарх мэдлэг мэдээлэл, цуврал хичээл;

7.5.4.бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх мэдлэг олгох мэдээлэл, цуврал хичээл;

7.5.7.малын өтөг бууц, аргал, хөрзөнг цэвэрлэх, боловсруулах, техник, технологийн мэдлэг;

7.6.Сургалт зохион байгуулсан байгууллага сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчид үнэмлэх, тэмдэг олгож, энэ талаарх

мэдээллийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага нь” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, 8.5 дахь хэсгийн “, 8.3.4” гэснийг тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4 дэх хэсэг нэмэх.

“8.2.Аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газрыг өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

8.4.Залуу малчин гэр бүлд болон хот, сууринаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 9, 10 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулж, 10.9 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага тус тус” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 10.10 дахь хэсэг нэмэх.

“10.3.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг, нөөц ашиглалтын түвшний өсөлт болон малчны хүлээх үүрэг, зохистой дадлын хэрэгжилтийг харгалзан улс, аймаг, сумын аварга малчин, тэргүүний малчны хоршоо, аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлнэ.

10.6.Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу халдварт өвчингүй, эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг баталгаажуулна.

10.10.Улсын аварга, хошой аварга малчин, саальчин, фермер шалгаруулах журам болон энэ хуулийн 10.4-т заасан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд урамшуулал

олгох журмыг Засгийн газар тус тус батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.6 дахь заалтын “малчны бүлгийн” гэснийг “хот айл, малчдын холбооны” гэж өөрчилж, 11.4.7 дахь заалтын “санаачлах аливаа малчны” гэснийг, 11.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 12, 13, 14 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12, 13, 14 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “Малчин нь” гэснийг “Малчид хамтын санаачилга, хоршилд үндэслэн” гэж өөрчилж, 15.2 дахь хэсгийг хасаж, 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.6.Бэлчээрийг хаших, хөрсийг эвдэх, мэргэжлийн байгууллагаас доройтсон болохыг тогтоосон бэлчээрээс ургамал түүх, хадахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “16.2-т заасан зээлийг” гэсний дараа “арилжааны банкны шаардлага болон” гэж нэмж, 16.5.10, 16.6.5, 16.6.6 дахь заалтыг тус тус хасаж, 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“16.7.Энэ хуулийн 16.2-т заасан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтын “урамшууллын нэг удаагийн орлогын хуваарилалт” гэснийг “урамшууллаас малчны зөвшөөрлийг үндэслэн хуваарилсан хөрөнгө” гэж өөрчилж, 17.2.5 дахь заалтыг хасаж, 17.7 дахь хэсгийн “хоршоо,” гэсний дараа “нөхөрлөл, компани,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 18, 19 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 20, 21 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

21 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

“21.1.Энэ хуулийн 5.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

21.2.Энэ хуулийн 16 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Ж.Батжаргал: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг мөн хэсгийн “бүтээмж бүхий” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “, чадваржуулах, оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, тогтвортой, чанартай амьдрах хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэснийг, 5.1.7 дахь заалтын “мал аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд” гэснийг, 5.1.8 дахь заалтын “дэмжлэг” гэснийг, 5.2.2 дахь заалтын “малчин өрхийн амьдралын чанарыг дээшлүүлэх үүднээс” гэснийг, 5.2.6 дахь заалтын “малчид жил тутам” гэснийг, 5.2.9 дэх заалтын “Тайлбар: Энэ заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.5.9 дэх заалтын “малчдын” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “хариуцан” гэснийг, 8.5 дахь хэсгийн “батлан” гэснийг, 8.10 дахь хэсгийн “үр дүнд” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “цахим малчныг хөгжүүлнэ” гэснийг, 9.2 дахь хэсгийн “тус тус” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хүчин зүйлсийг” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.4.4 дэх заалтын “тэргүүн” гэснийг, 11.4.7 дахь заалтын “зогсоох болон” гэснийг, 16.5.1 дэх заалтын “байгаль цаг уурын нөхцөлийг хангахуйц” гэснийг, 16.5.9 дэх заалтын “түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ хийлгэх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “бусад” гэснийг тус тус хасах.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “малчны үйл ажиллагаатай холбогдсон бусад” гэснийг “эдгээр хуультай нийцүүлэн гаргасан” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “мал аж ахуйн” гэснийг “био” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “сайжруулах” гэснийг “хамруулж, дэмжлэг” гэж, 5.2.4 дэх заалтын “үүднээс” гэснийг “зорилгоор орон сууцны” гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “, үнийн үнэлгээг тогтоож,” гэснийг “олгох замаар” гэж, 10.5 дахь хэсгийн “үржлийн ажлыг” гэснийг “үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “ашгийн төлөө байгууллага” гэснийг “нөхөрлөл, хоршоо, компани.” гэж, 11.3 дахь хэсгийн “Компанийн тухай болон Хоршооны тухай хуулиар зохицуулагдана.” гэснийг “холбогдох хуулиар зохицуулна.” гэж, 11.4.7 дахь заалтын “байгаль орчны” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “сантай байж” гэснийг “сан байгуулж” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтын “малчны, малчны бүлгийн” гэснийг “энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-г заасан этгээдийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэх сан” гэснийг “малчны хөгжлийн сан” гэж, 18.1.3 дахь заалтын “орон нутгийг хөгжүүлэх” гэснийг “орон нутгийн хөгжлийн сан” гэж, 18.1.4 дэх заалтын “сумын хоршооны” гэснийг “хоршоо хөгжүүлэх сан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Батжаргал: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.43, 6.64 дэх заалтын “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13.11 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 10 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 20 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
даваа гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 19 цаг 30 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ оройн амгалан амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Телуханы Аубакир, Батсүхийн Саранчимэг, Буланы Бейсен, Гочоогийн Ганболд, Гонгорын Дамдинням, Цагаанхүүгийн Идэрбат, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Төмөртоогоогийн Энхтүвшин нар хүрэлцэн ирж 52.6 хувийн ирцтэй байгаа тул өнөөдрийн хуралдааныг эхлүүлж байна аа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх 4 асуудал байна.

1. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг.

2. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг.

3. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэг.

4. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт саналтай гишүүд бий юу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүд та бүхэнд хүргүүлсэн.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг та бүгдэд танилцуулъя. Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Ц.Мөнхнасан ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын МАА-н бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, М.Найданхүү Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн зөвлөх, судлаач, А.Энх-Амгалан Бодлого судлалын төвийн тэргүүн.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн танилцуулна.

Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Та бүхэнд бас оройн мэндийг хүргэе. Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед санал хураагаад дэмжсэн боловч дахин хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу санал хураалгах шаардлагатай нэг асуудлыг ажлын хэсгээс бол танилцуулж байгаа.

Хууль санаачлагч Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд 52.2 дахь хэсгийг өөрчлөн найруулахдаа ИТХ-ын шийдвэрийг үндэслэн бэлчээр ашиглуулах гэрээг сумын Засаг дарга малчин өрхийн анхдагч холбоотой байгуулахад төсөлд тусгасан байсныг анхны хэлэлцүүлгийн явцад ИТХ-ын шийдвэрийг үндэслэн гэснийг хасах санал дэмжигдсэн боловч уг хэсгийг бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана.

Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлалтаас хамгаалах нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог бэлчээрийн даацыг харгалзан багийн ИНХ-ын саналыг үндэслэн сумын Засаг дарга, малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно гэж бүхэлд нь өөрчлөн найруулах нь зүйтэй гэж ажлын хэсгийн гишүүд үзсэн болно оо.

Ингээд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусгах нь төслийн агуулга бодлого зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэг хийсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэг хийсэн тухай танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томъёолол хэлэлцэн шийдвэрлэснийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Ж.Батжаргал: Тэмүүлэн гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу?
алга байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3

дахь хэсэгт заасныг баримтлан ажлын хэсгээс нэг саналын томъёолол бэлтгэсэн байна. Саналын томъёолол хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр зарчмын зөрүүтэй санал гарсан байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2.Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” гэсэн ийм саналын томъёолол бэлтгэгдсэн байна.

Энэ санал 3-ны 2-оор дэмжигдэх ёстой юм байна Дэгийн хуулиараа. Саяын уншсан саналын томъёоллоор санал хураалт.

70 хувиар дэмжигдсэн байна. Энэ чинь 3-ны 2-оор явахыг нь дэмжсэн тийм үү. Тэгэхээр одоо уншигдсан саналын томъёоллоор нь санал хураалт явуулна тийм үү?

Санал хураалт.

70 хувиар дэмжигдлээ.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж

ахуйн байнгын хорооны танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

19.36 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүд та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Суудлаа эзлээрэй.

Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Э.Уламбаяр ХХААХҮЯ-ны ХАА-н үйлдвэрлэлийн хяналтын хэлтсийн дарга ирсэн юм уу? Б.Уранчимэг ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Н.Отгонбаяр ХХААХҮЯ-ны Бордоо ургамал хамгаалал хөдөө аж ахуйн зохистой дадлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, М.Бямбасүрэн Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дарга, П.Болор-Эрдэнэ Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Ургамал хорио цээрийн хяналт хариуцсан улсын байцаагч. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар танилцуулна. Наранбаатар гишүүний микрофоныг өгөөрэй.

Н.Наранбаатар: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 5 сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуульд хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг гүйцээн боловсруулж, нэг зарчмын зөрүүтэй саналыг боловсруулаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Батжаргал: Наранбаатар гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтээс асуух асуулттай гишүүд бий юу? Алга байна. Ажлын хэсгээс нэг зарчмын

зөрүүтэй саналын томъёолол бэлтгэгдсэн.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна.” гэсэн ийм саналын томъёолол байна.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Наранбаатар танилцуулна. Аубакир гишүүн уншъя. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

19.39 цагт

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Б.Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал амьтны эрүүл мэндийн газрын дарга, С.Батхуяг

Мал эмнэлгийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүн ирсэн байна.

Чуулганы хуралдааны дэгийн хуулиар энэ чинь зүйл бүрээр нь хэлэлцэх ёстой билүү. Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу?

Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн мал амьтны эм гэсний дараа цаашид эм г гэж нэмэх саналтай байна. Зарчмын зөрүүтэй санал.

төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг мал амьтны эм гэсний дараа цаашид эм гэх гэж өөрчлөх юм байна тийм үү?

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 60 хувийн саналаар дэмжигдлээ.

Бейсен гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэлд аварай.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.5, 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1. “эм” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх зориулалттай, эм судлал, эмнэлзүйн болон бусад сорилт туршилтаар үйлдэл нь нотлогдсон нийлэг болон амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой хэлбэр, тун, хэмжээтэй бүтээгдэхүүнийг;”

“4.1.5. “оношлуур” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;”

“4.1.8. “эмийн туслах бодис” гэж эмийн гол үйлдлийг дэмжих, сөрөг нөлөөг бууруулах, амт, үнэрийг дарах ба нэмэгдүүлэх, эмийг хэлбэржүүлэх, найрлагыг тогтворжуулах, үйлдлийн ба хадгалах хугацааг уртасгах зэрэгт шаардлагатай бодисыг;” гэж оруулах саналтай байна аа.

Ж.Батжаргал: Наранбаатар гишүүний саяын гаргасан саналын томъёолол. Энд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор бичигдээд ирчихсэн юм байна. Саяын уншигдсан саналын томъёоллоор санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Наранбаатар гишүүнээс 1 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн юм байна. саналын томъёололыг уншиж хэлье.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “мал, амьтны эмийн зөвлөл” гэсний дараа “цаашид “Зөвлөл” гэх/”

гэж, 5.3.1 дэх заалтын “мал, амьтны эм,” гэсний дараа “биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл,” гэж тус тус нэмж, 5.4 дэх хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчлөх гэсэн ийм саналын томъёолол Наранбаатар гишүүнээс ирүүлсэн байна.

Саяын уншсан саналын томъёоллоор санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу?

Наранбаатар гишүүнээс нэг саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн юм байна.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “Мал, амьтны эмийн бүртгэлд /цаашид “бүртгэл” гэх/” гэж, 6.18 дахь хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3.8, 6.3.9 дэх заалт нэмэх:

“6.3.8.оношлуур;

6.3.9.тэжээллэг чанартай тэжээлийн нэмэлт.” гэж. Саяын уншсан саналын томъёоллоор санал хураалт.

70 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу?

Аубакир гишүүнээс саналын томъёолол бэлтгэгдэж ирсэн юм байна.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.13 дахь заалтыг хасах. Саяын уншсан томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Аубакир гишүүнээс нэг саналын томъёолол бэлтгэгдэж ирсэн байна.

Төслийн Гуравдугаар бүлэг болон 10 дугаар зүйлийн гарчгийн “тэжээлийн нэмэлтийн” гэснийг “тэжээлийн нэмэлт, оношлуурын” гэж өөрчилж, 10.2.3 дахь заалтын “мал, амьтны эмийн сан” гэсний дараа “/цаашид “эмийн сан” гэх/” гэж нэмэх. Саяын уншигдсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүд байна уу? Аубакир гишүүнээс нэг саналын томъёолол бэлтгэгдэж ирсэн байна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хасах. Саяын уншигдсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу?

Аубакир гишүүн нэг саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн байна.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 15.12.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас импортлох, экспортлох энгийн зөвшөөрлийг авна.”

“15.12.6.хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөн нь тогтоогдсон;” ийм саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн байна.

Санал хураалт явуулъя.

Санал хураалт 70 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу?

Энд нэг саналын томъёолол бэлтгэгдсэн байна.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн 8.1 дүгээр зүйлийн 12.12 гэснийг 8.1 дүгээр зүйлийн 12.12-т заасан тусгай зөвшөөрлийг мал амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэж өөрчилж, 17.2 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг

зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.”

“17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:” гэсэн ийм саналын томъёолол байна. Батжаргал гаргаж байна аа. Саяын саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3, 17.3.4, 17.4.4, 17.8.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан Батжаргал.

Саяын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн бий юу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн бий юу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүд байна уу? Энд нэг санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Мал эмнэлгийн эмийг” гэснийг “Эм, тэжээлийн нэмэлтийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“20.11.Мал, амьтны эрдэс бодисын дутлыг тодорхойлох тандан судалгааг энэ хуулийн 20.12-т заасан байгууллагын захиалгаар сургалт, эрдэм шинжилгээний байгууллага таван жил тутамд бүсчлэн хийнэ.

20.12.Энэ хуулийн 20.11-д заасан тандан судалгааг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс бодисын дутлыг нөхөх, хэрэглэх талаар зөвлөмж гаргана.

20.13.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь энэ хуулийн 20.12-т заасан зөвлөмжийн дагуу шаардлагатай эрдэс бодисыг агуулсан эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэнэ.” Саяын уншсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Энд миний бэлтгэсэн нэг санал байна.

Төслийн 22 дугаар зүйлийн 22.4.4 дэх заалтыг хасах.

Санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Энд миний бэлтгэсэн нэг санал байна.

Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын нэг хэдэн санал байна.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “хэлбэр,” гэсний өмнө “гол үйлчлэгч бодис, ” гэж, 6.7.5, 6.8.5 дахь заалтын “хорон” гэсний дараа “, эсхүл хоруу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “үр дүнгийн” гэсний дараа “харьцуулсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “хүртээмжтэй” гэсний дараа “тогтвортой” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бөөнөөр ханган нийлүүлэх” гэсний өмнө “эмийн санд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын “түдгэлзүүлэх,” гэсний дараа “цуцлах” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтын “тайланг хэлэлцэж, зөвлөмж өгөх” гэснийг “тайлантай танилцах” гэж, 5.6 дахь хэсгийн “төсөвт тусган санхүүжүүлнэ” гэснийг “төсвийн төсөлд тусгана” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “тусламжаар импортлох” гэснийг “тусламж, хандивын” гэж, 6.3.2 дахь заалтын “эм” гэснийг “бүтээгдэхүүн” гэж, 6.4 дэх хэсгийн “зориулалтыг зааж” гэснийг “зориулалт, жороор олгох эсэхийг зааж” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалтын “үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “хүн эмнэлгийн зориулалт бүхий” гэснийг “хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “лиценз” гэснийг “энгийн зөвшөөрөл” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл,

ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо” гэснийг “Энгийн зөвшөөрөл хүсэгч нь” гэж, 17 дугаар зүйлийн 17.8.1 дэх заалтын “бүрдүүлж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих” гэснийг “бүрдүүлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “журам, эмийн жагсаалтыг” гэснийг “журмыг” гэж, 20.5 дахь хэсгийн “бүртгээж, улирал бүр цахим мэдээллийн санд оруулна” гэснийг “бүртгэнэ” гэж, 20.7 дахь хэсгийн “сөрөг үйлдэл болон хэрэглээний горимыг” гэснийг “гаж нөлөө, хэрэглэх зааврыг” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 11.2.2 дахь заалтын “эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мал эмнэлгийн байгууллага, мал, амьтны эмийн санд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.10.2 дахь заалтын “хамтын ажиллагааны болон төслийн” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн тогтоож, өөрийн орны судалгааны дүн болон” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.3.7 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх

Санал хураалт.

60 хувийн саналаар дэмжигдлээ.

Ингээд Мал амьтны эрүүл мэнд эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг явуулъя.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Энд миний бэлтгэсэн нэг санал байгаад байгаа юм.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах ийм санал байна аа.

Санал хураалт явуулъя.

Бейсен гишүүн горимын санал гаргая.

Б.Бейсен: Миний төхөөрөмж ажиллахгүй байсан. Дахин санал хураалгаж өгнө үү?

Ж.Батжаргал: Бейсен гишүүний горимын саналаар саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Бейсен гишүүний горимын санал дэмжигдэж өмнөх санал хураалт хүчингүй болсон тул түрүүний уншсан хуулийн төслийг санаачлагчид нь буцаая гэдэг саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя.

Санал хураалт 60 хувийн саналаар дэмжигдэж, хуулийн төслийг буцаалаа. Түрүүний горимын санал бас 60 хувиар дэмжигдсэн байсан шүү тэрийг юунд нь оруулчихъя. Юу билээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хоёрдугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд бий юу? Байхгүй байна.

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Саранчимэг гишүүн танилцуулна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

20.00 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Ц.Мөнхнасан ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн.

Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн танилцуулгыг би та бүгдэд хүргэе.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 17 гишүүнээс 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ахлагчаар нь Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, гишүүдэд Ганибал, Саранчимэг, Идэрбат, Энхтүвшин нар ажиллалаа.

Дэд ажлын хэсэг 3 удаа, ажлын хэсэг 2 удаа хуралдаж, 18 зарчмын зөрүүтэй саналын томъёолол боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Хуулийн төсөлд малчдын залгамж халааг бэлтгэх бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог бэлчээр ашиглаж ирсэн уламжлалт зан заншилыг хадгалах хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлэх, малчны хөгжил, бүтээмж, малчны эрх, үүргийг тодорхой болгож, мал аж ахуйн зохистой дадлын хэрэгжүүлэх, малын эрүүл мэнд, үржүүлэх технологийн ажил үйлчилгээ, мал маллагаа, тэжээл хангамж, МАА-н үйл ажиллагааг хөнгөвчлөх шинэ арга техник технологи зэргийг дэмжин хөгжүүлж малчны болон салбарын бүтээмж үр ашгийг нэмэгдүүлэх, Мөн малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх, Мал, малын гаралтай, чанартай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхдээ бүртгэл хяналтын тогтолцооны үйл ажиллагааг мэдээлэл технологид суурилсан баталгаажуулалтад үндэслэн хийх, малчны хамтын үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, малчин орон нутагтаа ая тухтай ажиллаж амьдрах

нөхцөлийг бүрдүүлэх, залуу малчдыг дэмжих, малчинд зориулсан хөгжлийн болон эргэлтийн хөрөнгийн зээлийн санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгасан.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн гишүүдээс боловсруулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүд Батжаргал, Саранчимэг, Идэрбат, Энхтүвшин гэсэн ийм бүрэлдэхүүн байна.

Анхны хэлэлцүүлэг учраас мөн зүйл бүрээр нь хэлэлцэж явах ёстой тийм үү? Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулж асуух зүйл байхгүй биз дээ? Алга байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Ажлын хэсгээс нэг санал бэлтгэгдсэн.

Төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Санал хураалт.

Байнгын хорооны гишүүн Аубакирын горимын саналаар санал хураалтын тоног төхөөрөмж гацаад бас тодорхой цаг хугацаа аваад байгаатай холбогдуулаад санал хураалтыг гараа өргөөд санал хураалт явуулъя гэдэг саналыг дэмжье гэсэн саналтай байгаа.

Санал хураалт.

Дэмжье гэсэн санал.

5 гишүүн дэмжиж саяын гаргасан санал унаж байна шүү. Тэмүүлэн гишүүн санал гаргая.

Г.Тэмүүлэн: Дэмжсэн боловч сая эсрэгээр гарчихлаа. Тэгээд төхөөрөмжөөр гарчих шиг боллоо. Дахиад санал хураалтыг явуулъя.

Тэмүүлэн гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувиар дэмжигдэж өмнөх санал хураалт хүчингүй боллоо. Аубакир гишүүний түрүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувийн саналаар дэмжигдэж, гараар санал хураалт явуулахаар боллоо.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Ажлын хэсгээс нэг санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд шинээр 4.1.7, 4.1.8 дахь заалт нэмэх.

“4.1.4. “хот айл” гэж хоёр ба түүнээс дээш малчин өрх хамтран хөдөлмөрөө хоршин мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрийг;

4.1.5. “мал аж ахуйн зохистой дадал” гэж бэлчээрийг хамгаалах, мал маллагаа, малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, ашиг шим, түүхий

эдийн чанар, аюулгүй байдлыг хангах арга барил, үйл ажиллагааг;

4.1.7. “мал” гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.8. “малчин өрх” гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-д заасныг.”

Санал хураалт. 10-аас 6 дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дахь заалтын “урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд” гэсний дараа “хамрагдах хүсэлт гаргасан малчныг жил бүр” гэж нэмж, 5.1.6 дахь заалтыг 5.1.6, 5.1.7 дахь заалт болгож, 5.2, 5.3 дахь хэсэг, 5.2.1, 5.2.3, 5.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“5.1.6.мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэл даах чадавхыг бүрдүүлэх;

5.1.7.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшинг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх;

5.2.Засгийн газраас энэ хуулийн 5.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэхээс гадна дараах арга хэмжээг авна:

5.2.1.мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт, шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

5.2.3.мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хөнгөлөлттэй зээл болон бусад хэлбэрээр дэмжих;

5.2.7.гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин нь ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгох;

5.3.Энэ хуулийн 5.2.4, 5.2.5, 5.2.6, 5.2.7, 5.2.8, 5.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдох харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.”

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу?

Ажлын хэсгээс 1 саналын томъёолол бэлтгэсэн байна.

Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, ГУРАВДУГААР БҮЛЭГТ илжжүүлэх.

МАЛЧНЫ ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

6 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг

6.1.Малчин дараах эрх эдэлнэ:

6.1.1.уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн нөхцөлд мал маллах арга ухааныг эзэмшиж, мэдлэг, туршилага, ур чадвар, арга барилаа ахиулж, малчинд зориулсан сургалт мэдээлэл, зөвлөгөө авах;

6.1.2.байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах;

6.1.3.төрөөс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээ авах;

6.1.4.малын эрүүл мэндийг хамгаалах болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг эрх бүхий нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, зөвлөгөө авах;

6.1.5.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, нэр төрөл, чанараас хамаарсан урамшууллыг хууль тогтоомжийн дагуу авах;

6.1.6.хуульд заасан бусад эрх.

6.2.Малчин дараах үүрэг хүлээнэ:

6.2.1.байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

6.2.2.мал маллагааны уламжлалт болон шинжлэх ухаанч арга барилыг эзэмших;

6.2.3.малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах;

6.2.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах;

6.2.6. хуульд заасан бусад.

6.3.Энэ хуулийн 6.2.1-д заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.3.1.малчин өрх, хот айл бэлчээрээ дундаа хамтран ашиглаж ирсэн уламжлалд тулгуурлан харилцан зөвшилцөж, зохион байгуулалтад орсон байх;

6.3.2.бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ

байгуулах үеийн тогтоосон суурь түвшинээс бууруулахгүй байх;

6.3.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хадлан, гар тэжээл бэлтгэх.

6.4.Энэ хуулийн 6.2-2-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.4.1.мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг өөрийн малын тоо толгойд нийцүүлэн бүрэн хангаж, 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, тэжээл бэлтгэж нөөцлөх;

6.4.2.малын хэвтэр бууц, хашаа, хороог байнга цэвэрлэж, өвөлжөөний хэрзэнг жил бүр авдаг, өтөг хэрзэнг овоолж хэвтрийн нөөц бүрдүүлдэг байх;

6.4.3.өвөлжөө, хаваржааны дулаан хашаа, хороо, байр барьж ашиглах;

6.4.4.дөрвөн улиралд нүүдэллэн бэлчээр ашиглахдаа байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдлыг ил задгай үлдээхгүй байх;

6.4.5.худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлах;

6.4.6.мал маллах, хариулах, тууварлах, тээвэрлэхдээ уламжлалт арга барилыг түлхүү ашиглах.

6.5.Энэ хуулийн 6.2.3-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.5.1.тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн, баталгаажсан үүлдэр, омгийн хээлтүүлэгч ашиглах, малыг ялган тэмдэглэх, бүртгэлд хамруулах;

6.5.2.малын төрлийн харьцаа, сүргийн зохистой бүтцийг хангаж, эдийн засгийн эргэлтэд оруулах;

6.5.3.тухайн үүлдэр, омгийн нэгж малаас авч болох ашиг шимийн дундаж гарцаас багагүй хэмжээний ашиг шим авах;

6.5.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 3 жил тутамд чанарын үнэлгээ хийлгэх;

6.5.5.мал эмнэлгийн болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг мэргэжлийн нэгжээр гэрээний үндсэн дээр технологит хугацаанд гүйцэтгүүлэх;

6.5.6.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, гарал үүслийг тогтоох нөхцөлийг бүрдүүлж, малын шилжилт хөдөлгөөний талаар эрх бүхий байгууллагад мэдээлдэг байх;

6.5.7.эмийн үлдэц агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

6.6.Энэ хуулийн 6.2.4-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.6.1.малын ноос, ноолуур, хөөврийг технологийн хугацаанд холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын ялгаатай байдлаар ангилан тордож, бэлтгэн нийлүүлэх;

6.6.2.малын мах бэлтгэлийг хийхдээ малын арьс ширийг механик гэмтэлгүйгээр хоёр цагийн дотор цэвэрлэгээ, анхан шатны тордолтыг хийж, холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын хамгаалалттайгаар бэлтгэх;

6.6.3.сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхдээ эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан байх.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгээс бэлтгэсэн 1 санал байна.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.6 дахь хэсэг, 7.5.3, 7.5.4, 7.5.7 дахь заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулж, 7.2 дахь хэсгийг хасах.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан хөтөлбөр нь сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцсэн байна.

7.5.3.малын чанарыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал маллах, арчлах болон сувилгааны арга аргачлалын талаарх мэдлэг мэдээлэл, цуврал хичээл;

7.5.4.бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх мэдлэг олгох мэдээлэл, цуврал хичээл;

7.5.7.малын өтөг бууц, аргал, хөрзөнг цэвэрлэх, боловсруулах, техник, технологийн мэдлэг;

7.6.Сургалт зохион байгуулсан байгууллага сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчид үнэмлэх, тэмдэг олгож, энэ талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг санал байна.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага нь” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, 8.5 дахь хэсгийн “, 8.3.4” гэснийг, тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4 дэх хэсэг нэмэх.

“8.2.Аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газрыг өөр чиглэлээр давхиулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

8.4.Залуу малчин гэр бүлд болон хот, сууринаас ишлэжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.”

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, санал байна уу? алга байна.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Ажлын хэсгээс 1 санал гарсан байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулж, 10.9 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага тус тус” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 10.10 дахь хэсэг шинээр нэмэх.

“10.3.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг, нөөц ашиглалтын түвшиний өсөлт болон малчны хүлээх үүрэг, зохистой дадлын хэрэгжилтийг харгалзан улс, аймаг, сумын аварга малчин, тэргүүний малчны хоршоо, аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлнэ.

10.6.Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу халдварт өвчингүй, эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг баталгаажуулна.

10.10.Улсын аварга, хошой аварга малчин, саальчин, фермер шалгаруулах журам болон энэ хуулийн 10.4-т заасан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд урамишуулал олгох журмыг Засгийн газар тус тус батална.”

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс санал бэлтгэсэн байна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.6 дахь заалтын “малчны бүлгийн” гэснийг “хот айл, малчдын холбооны” гэж өөрчилж, 11.4.7 дахь заалтын “санаачлах аливаа малчны” гэснийг, 11.5 дахь хэсгийг тус тус хасах.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс 1 санал бэлтгэсэн байна.

Хуулийн төслийн 12, 13, 14 дүгээр зүйлийн хасах.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс санал бэлтгэсэн байна.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “Малчин нь” гэснийг “Малчид хамтын санаачилга, хоршилд үндэслэн” гэж өөрчилж, 15.2 дахь хэсгийг хасаж, 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“15.6.Бэлчээрийг хаших, хөрсийг эвдэх, мэргэжлийн байгууллагаас доройтсон болохыг тогтоосон бэлчээрээс ургамал түүх, хадахыг хориглоно.” Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс санал бэлтгэсэн байна.

Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “16.2-т заасан зээлийг” гэсний дараа “арилжааны банкны шаардлага болон” гэж нэмж, 16.5.10, 16.6.5, 16.6.6 дахь заалтыг тус тус хасаж, 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“16.7.Энэ хуулийн 16.2-т заасан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгана.”

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг санал байна.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтын “урамиууллын нэг удаагийн орлогын хуваарилалт” гэснийг “урамиууллаас малчны зөвшөөрлийг үндэслэн хуваарилсан хөрөнгө” гэж өөрчилж, 17.2.5 дахь заалтыг хасаж, 17.7 дахь хэсгийн “хоршоо,” гэсний дараа “нөхөрлөл, компани,” гэж нэмэх.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн 1 санал байна.

Төслийн 19 дүгээр зүйлийг хасах.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн 1 санал бэлтгэсэн байна.

Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

21 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

“21.1.Энэ хуулийн 5.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

21.2.Энэ хуулийн 16 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Найруулгын 3 санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг мөн хэсгийн “бүтээмж бүхий” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “, чадваржуулах, оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, тогтвортой, чанартай амьдрах хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэснийг, 5.1.7 дахь заалтын “мал аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд” гэснийг, 5.1.8 дахь заалтын “дэмжлэг” гэснийг, 5.2.2 дахь заалтын “малчин өрхийн амьдралын чанарыг дээшлүүлэх үүднээс” гэснийг, 5.2.6 дахь заалтын “малчид жил тутам” гэснийг, 5.2.9 дэх заалтын “Тайлбар: Энэ заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний

өдрийг хуртэл дагаж мөрдөнө.” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.5.9 дэх заалтын “малчдын” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “хариуцан” гэснийг, 8.5 дахь хэсгийн “батлан” гэснийг, 8.10 дахь хэсгийн “үр дүнд” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “цахим малчныг хөгжүүлнэ” гэснийг, 9.2 дахь хэсгийн “тус тус” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хүчин зүйлсийг” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.4.4 дэх заалтын “тэргүүн” гэснийг, 11.4.7 дахь заалтын “зогсоох болон” гэснийг, 16.5.1 дэх заалтын “байгаль цаг уурын нөхцөлийг хангахуйц” гэснийг, 16.5.9 дэх заалтын “түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ хийлгэх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “бусад” гэснийг тус тус хасах.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “малчны үйл ажиллагаатай холбогдсон бусад” гэснийг “эдгээр хуультай нийцүүлэн гаргасан” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “мал аж ахуйн” гэснийг “био” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “сайжруулах” гэснийг “хамруулж, дэмжлэг” гэж, 5.2.4 дэх заалтын “үүднээс” гэснийг “зорилгоор орон сууцны” гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “, үнийн үнэлгээг тогтоож,” гэснийг “олгох замаар” гэж, 10.5 дахь хэсгийн “үржлийн ажлыг” гэснийг “үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “ашигийн төлөө байгууллага” гэснийг “нөхөрлөл, хоршоо, компани.” гэж, 11.3 дахь хэсгийн “Компанийн тухай болон Хоршооны тухай хуулиар зохицуулагдана.” гэснийг “холбогдох хуулиар зохицуулна.” гэж, 11.4.7 дахь заалтын “байгаль орчны” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “сантай байж” гэснийг “сан байгуулж” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтын “малчны, малчны бүлгийн” гэснийг “энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан этгээдийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэх сан” гэснийг “малчны хөгжлийн сан” гэж,

18.1.3 дахь заалтын “орон нутгийг хөгжүүлэх” гэснийг “орон нутгийн хөгжлийн сан” гэж, 18.1.4 дэх заалтын “сумын хоршооны” гэснийг “хоршоо хөгжүүлэх сан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх.

Санал хураалт.

10-6 дэмжлээ.

Малчны тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Малчны тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй. Ажлын хэсгээс санал гараагүй.

Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал байгаа юм байна.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах 1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.43 6.64 дэх заалтын 15.2 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт гэснийг 15.2 дугаар зүйлийн нэг дэх хэсэг 13.11 дүгээр зүйлд гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт.

10-6.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу байхгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Малчны тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Энхтүвшин гишүүн танилцуулна.

Байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг өндөрлүүлж байна.

Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

Ингээд хурал өндөрлөлөө.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА